



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

**Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн
үеийн бэлэн байдал, хариу арга
хэмжээний бодлого, чиглэл**

Д.Баярболд-ЭМЯ-ны НЭМГ-ын Халдварт өвчний хэлтсийн дарга

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГҮҮД

1. Нийгмийн эрүүл мэндийн тандалт, хяналт

2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын удирдлага

3. Нийгмийн эрүүл мэндийн удирдлага

4. Нийгмийн эрүүл мэндийн салбар хоорондын төлөвлөлт, санхүүжилт, менежмент

5. Эрүүл мэндийг хамгаалах

ЭМТХ 3.1.2. "эрүүл мэндийг хамгаалах" гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг;

6. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх



7. Эрүүл мэндийг дэмжих

ЭМТХ 3.1.19. "эрүүл мэндийг дэмжих" гэж хүн амын эрүүл мэндийг хянах, бэхжүүлэх, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг.

8. Олон нийтийг дэмжих ба нийгмийн оролцоо

9. Нийгмийн эрүүл мэндийн ажиллах хүчний хөгжил

10. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, тэгш байдал

11. Нийгмийн эрүүл мэндийн судалгаа, үнэлгээ, мэдлэг

12. Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, хангамж, тоног төхөөрөмж, технологийн хүртээмж, ашиглалт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

Үндэслэл

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт-2030
- Алсын хараа-2050
- Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр



Өргөн мэдүүлсэн:
УИХ-ын даргад
2023.06.28



Баталсан :
Улсын Их Хурал
2024.01.12



Дагаж мөрдөх :
2024.04.01



Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээ



Нийгмийн эрүүл мэндийн
тусламж үйлчилгээ



Эмнэлгийн
тусламж үйлчилгээ

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
тухай хууль **7** бүлэг, **22** зүйлтэй

ХУУЛИЙН ДАГУУ БАТЛАГДАХ ЭРХ ЗҮЙН АКТУУД



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газрын тогтоолоор батлах

1. **НЭМ-ийн орон тооны бус үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам**
2. **НЭМХАҮТөвийг байгуулах шийдвэр болон төвийн дүрэм**
3. Аймаг, дүүрэгт **НЭМТ-үүд** байгуулах шийдвэр



Хамтарсан тушаалаар батлах

1. **НЭМТҮ-ний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, хяналт тавих журам**- Сангийн сайдтай хамтран батлах
2. **НЭМ-ийн мэдээллийн сангийн ажиллах журам**- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай хамтран батлах
3. **НЭМ-ийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журам**- Монгол Улсын Шадар сайдтай хамтран батлах



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

ЭМСайдын тушаалаар батлах

1. **НЭМАХҮТөвийн бүтэц**
2. **НЭМТ-ийн дүрэм, бүтэц**
3. **НЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагааны стандарт**
4. Эрүүл мэндийн байгууллагуудын **НЭМ-ийн нэгж, албаны бүтэц, дүрэм**
5. **НЭМТҮ-д олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журам**

2.3. Эрүүл монгол хүн

2.3.1. Нийгмийн эрүүл мэнд

2.3.1.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх **дэд төвийг бүс бүрд** байгуулна.

2.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж

2.3.2.7. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын стандартын дагуу бүрдүүлж, **их өгөгдөл үүсгэнэ.**

ШИНЭЧЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНҮҮД



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТЛАХ БОДЛОГО

ЮУГ?



НЭМТҮ-г тодорхойлох

- ✓ НЭМТҮ-ний **хүрээ болон багцыг** тодорхойлох
- ✓ МУ-ын **урт болон дунд хугацааны бодлого**той **хөгжлийн** уялдуулан төлөвлөх
- ✓ Нийгмийн эрүүл мэндийн **тэргүүлэх чиглэл**үүдийг тодорхойлох
- ✓ Хяналт үнэлгээ хийх **шалгуур үзүүлэлтүүд**ийг нарийвчлан тодорхойлох

ХЭНЭЭР ХИЙЛГЭХ?



НЭМТҮ үзүүлэх байгууллагууд

- ✓ Үндэсний төвүүд (НЭМҮТ,)
- ✓ Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
- ✓ Нийгмийн эрүүл мэндийн төв
- ✓ Төв эмнэлэг, нэгдсэн эмнэлэг болон бусад эрүүл мэндийн байгууллага
- ✓ **Анхан шат**
- ✓ Төрийн бус байгууллага
- ✓ Бусад НЭМТҮ үзүүлэгч байгууллага

ЯМАР ТӨСВӨӨР?



НЭМТҮ-г санхүүжүүлэх эх үүсвэр

- ✓ СЯ-тай **төсөв шийдвэрлэх** асуудлыг тохиролцох
- ✓ Улсын төсөв болон эрүүл мэндийг дэмжих сангийн **санхүүжилтийг нэмэгдүүлэх**
- ✓ Донор байгууллагын **эх үүсвэрийг үр дүнтэй, цогц** байдлаар ашиглах
- ✓ Иргэд, ААН, байгууллагын **хандив, тусламжийг нэмэгдүүлэх** боломж
- ✓ Орон нутгийн **төсвийг илүү үр дүнтэй** үйл ажиллагаа руу чиглүүлэх

ХЭРХЭН ХИЙЛГЭХ?



НЭМТҮ-г санхүүжүүлэх аргачлал

- ✓ НЭМТҮ-г санхүүжүүлэх **төлбөрийн нийтлэг аргыг** тодорхойлох
- ✓ Жил бүр **нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө** батлах
- ✓ **Салбар дундын оролцоог** хангах
- ✓ Ил тод байдлыг сайжруулах, **хөндлөнгийн хяналтыг** нэмэгдүүлэх
- ✓ **Олон нийтийг** татан оролцуулах хөшүүрэг бий болгох

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ



ЖУРМЫН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ- ХУВИЛБАР 1

Эх үүсвэр дайчлах

ОРЛОГО

- ✓ **Эрүүл мэндийг дэмжих**- Хүн амын тоогоор болон дэмжих сан
- ✓ **НЭМАХҮТөв (CDC)**- Хөтөлбөрт суурилсан
- ✓ **Салбар дундын асуудал (Сэтгэц, эрүүл мэндийг хамгаалах)**- Хөтөлбөрт суурилсан
- ✓ **Судалгаа**- Сан үүсгэж гэрээгээр
- ✓ **Өвчний хяналт, сэргийлэлт**- Эрүүл мэндийн даатгалын сан
- ✓ **Гамшиг, НЭМ-ийн ноцтой байдал-ЗГ** болон аймгийн нөөц сан
- ✓ **НЭМ-ийн бодлого, удирдлага**- Хөтөлбөрт суурилсан

Санхүүжилтийн нэгтгэл



Улсын төсөв
/сайдын багц,
дэмжих сан/

Донор байгууллага

Бусад хандив,
тусламж

Орон нутгийн төсөв

Бусад хандив,
тусламж



Худалдан авах

АНХААРАХ ЗҮЙЛС

1. Эрүүл мэндийн яам
2. Шалгуур үзүүлэлт
3. Бодлогод нийцүүлэн төлөвлөх

Худалдан авах төлбөрийн аргыг тусад нь тодорхойлох

Сангийн яамтай тохирох- Орлогыг бүрдүүлэхэд нотолгоо, судалгаа шаардлагатай

ЖУРМЫН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ- ХУВИЛБАР 2

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

АСУУДАЛ

- ✓ Тусламж, үйлчилгээний багц тодорхойлолт
- ✓ Бодлогын чиглэл
- ✓ Бодлогын чиглэлийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- ✓ Тэргүүлэх чиглэл тодорхойлж эрэмблэх
- ✓ Хэрэгжилтэд тавих хяналт

Төсөв /Эх үүсвэр дайчлах/



Худалдан авагч

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЯАМ
/Худалдан авах
зарчмаар/

ЭМГазар

Үйлчилгээ үзүүлэгч /хэрэгжүүлэх/

- ✓ Төлөвлөгөөний дагуу төсөв НЭМАХҮТ-д хуваарилагдана
- ✓ ЭМГ
- ✓ Эрүүл мэндийн төв
- ✓ Анхан шат
- ✓ Анхан шат
- ✓ Төрийн бус байгууллага

Засаглал


Үндэсний зөвлөл
(Засгийн газар)




Эрүүл мэндийн сайд
(Эрүүл мэндийн яам)



НЭМАХҮТөв
(Тандалт, судалгааны үндэсний төвүүд)



Орон нутаг
(ЭМГ, НЭМТ, ЗДТГ)



Анхан шат
(Сум, тосгон, өрхийн ЭМТ, Эрүүл мэндийн байгууллага)

ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

МУ-ын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого

- ✓ Алсын хараа-2050
- ✓ МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- ✓ МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- ✓ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал



Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны хөгжлийн бодлого

- ✓ Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө
- ✓ Үндэсний хэмжээний хөтөлбөрүүд
- ✓ Арга хэмжээний төлөвлөгөөнүүд (2024-2028 он)
- ✓ Хөгжлийн хөтөлбөрүүд



Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн чиглэл, багц

- ✓ Тусламж, үйлчилгээний багц, түүнийг хэрэгжүүлэх
- ✓ Санхүүжүүлэх төлбөрийн арга
- ✓ Эх үүсвэр бүрдүүлэх (улсын төсөв, ЭМД, хандив, тусламжийн орлого, төлбөрт үйлчилгээ)
- ✓ Хяналт- шинжилгээ, үнэлгээ



5 сарын 15

- ✓ Үндэсний төвүүд
- ✓ Аймаг, нийслэлийн ЭМГ
- ✓ **Донор байгууллага**

5 сарын 30

НЭМАХҮТ

6 сарын 10

Тухайн оны арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, төсөвлөлт

- ✓ Эрүүл мэндийн яам

12 сарын 20

Төсвийн дагуу батлан
НЭМАХҮТ хүргүүлнэ
Эрүүл мэндийн яам

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ 1. МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТ

№	Үндсэн тусламж, үйлчилгээний багц	Дэд багц	Тусламж, үйлчилгээ	НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА						САЛБАР ДУНДЫН ХАМТЫН		Олон улсын болон иргэний нийгмийн байгууллага			
				АНХАН ШАТЛАЛЫН		ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН		БУСАД БАЙГУУЛЛАГА		ЭМГ /НЭМТ	НЭМАХҮТ		ЭМДЕГ/ ЭМХТ	Хариуцах салбар	Дэмжих салбар
				Өрхийн эрүүл мэндийн төв	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Түргэн тусламжийн төв/Сувилал/Сувилахуйн төв/Сэргээн засах төв/Хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв/Тусгай							
Нэг. Эрүүл мэндийн салбарын өвчлөл болон нас баралт, бусад салбарын мэдээлэл															
1.1	Эрүүл мэндийн салбар108	Өвчлөл, нас баралтын бүртгэл, мэдээлэл	Халдварт өвчин: • Амьсгалын замаар дамжих халдвар • Хоол боловсруулах замаар дамжих халдвар • Байгалийн голомтот болон мал амьтнаас хүнд дамжих халдвар • Бэлгийн замаар дамжих халдвар • Цусаар дамжих халдвар • Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар	√	√	√	√	√	√	√	ЭМЯ	√			

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ 2. ӨВЧНИЙ ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТ

Үндсэн тусламж, үйлчилгээний багц	Дэд багц	Тусламж, үйлчилгээ	НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА						САЛБАР ДУНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА		Олон улсын болон иргэний нийгмийн байгууллага		
			АНХАН ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГА		ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГА		БУСАД БАЙГУУЛЛАГА		ЭМГ/ НЭМТ	НЭМАХҮТ		Хариуцах салбар	Дэмжих салбар
			Өрхийн эрүүл мэндийн төв	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Түргэн тусламжийн төв/Сувилал/Сувилахуйн төв/Сэргээн засах төв/Хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв/Тусгай эмнэлэг/Тусгай мэргэжлийн төв						
Халдварт өвчний тандалт, эрсдэлийн үнэлгээ • өвчин, аюул занал, эмзэг байдлыг тандах хүчтэй тандалтын тогтолцоо; • эмгэг төрүүлэгч, геномын тандалт хийх үр	Тохиолдолд суурилсан тандалт65:	Халдварт өвчний тархвар зүйн үнэлгээ, дүгнэлт хийх	√	√	√	√	√	√	√	ЭМЯ, ХХААХҮЯ	БЯ, ЦХИХХЯ, БХЯ, ЗДТГ, ААН	√	
		Ойрын хавьтлын тандалт судалгаа хийх	√	√	√	√	√	√	√	√	БЯ, ЗДТГ, ААН	√	
		Хавьтлуудад өвөрмөц болон хими сэргийлэлт хийх (менингококкт халдвар, балнад, иж балнад)	√	√	√	√	√	√	√	√	ЭМЯ	БЯ, ЗДТГ, ААН	√
		Цочмог халдварт өвчний шалтгаант нас баралтын тохиолдлыг маягтын дагуу мэдээлэх	√	√	√	√	√	√	√	√	ЭМЯ	ЗДТГ, ААН	√
		Эрсдэлт бүлгийн хүн амын бүртгэлийг шинэчлэх	√	√	√	√	√	√	√	√	ЭМЯ	ХХААХҮЯ, ЗДТГ, ААН	√
		ОУЭМД-ийн дагуу яаралтай мэдээлэх, бүртгэх	√	√	√	√	√	√	√	√	ЭМЯ	БЯ, ЦХИХХЯ, ХХААХҮЯ, ОБЕГ, ГХЯ, ЗДТГ	√

1.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ 3.1. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ

№	Үндсэн тусламж, үйлчилгээний багц	Дэд багц	Тусламж, үйлчилгээ	НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА				САЛБАР ДУНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА		БУСАД ОРОЛЦОГЧ
				АНХАН ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГА	ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ/ ТУСГАЙ ЭМНЭЛЭГ	ЭМГ/НЭМТ	НЭМАХҮТ	Хариуцах салбар	Дэмжих салбар	Олон улсын болон иргэний нийгмийн байгууллага
Нэг. Орчны эрүүл мэнд										
1.1	Гадаад орчны агаар6	Тээвэр	Утаа бага ялгаруулдаг нийтийн тээвэр, ачаа тээвэр, хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэлд шилжих				√	ЗТЯ	БОУАӨЯ, ЭМЯ	√
			Хүхрийн агууламж багатай шатахуун хэрэглэхийг дэмжих				√	АҮЭБЯ	ЗТЯ, ЭМЯ, БОУАӨЯ	
			Импортоор орж ирж буй тээврийн хэрэгслийн насжилтад хяналт тавих (наснаас хамаарсан татвар, CO2-ын ялгарал болон моторын хэмжээнд тохирсон онцгой албан татвар, цахилгаан болон хагас цахилгаан гм)				√	ЗТЯ	СЯ, ЭМЯ	
		Эрчим хүч	Халаалт, гэрэлтүүлэгт эрчим хүчний шийдлийг хямд зардлаар ашиглах боломжийг бүрдүүлэх Түүхий нүүрсний хэрэглээг зогсоох, цэвэр эрчим хүчний технологид шилжих				√	ЭХЯ	БОУАӨЯ, ЭМЯ, ЗДТГ	

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ 3.2. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДАЛ

№	Үндсэн тусламж, үйлчилгээний багц	Тусламж, үйлчилгээ	НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА				
			АНХАН ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА	ЭМГ/НЭМТ	ТЭРГҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА А	ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА А	ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА
1	Бэлэн байдлын чадавх бүрдүүлэлт	Шуурхай удирдлагын тогтолцоо/Шуурхай удирдлагын нэгж-ийн үйл ажиллагаа, Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ийн Үндэсний зохицуулах байгууллага (ҮЗБ)-ын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, бэжжүүлэх, өргөжүүлэх	√	√	√		ОУБ
		ДЭМБ-ын бүсийн төв бусад ОУБ-тай мэдээлэл солилцох үйл ажиллагаа			√		
		Үндсэн зохицуулалт40,41,64	• Бэлэн байдал, хариу арга хэмжээний бодлогын баримт бичиг (төлөвлөгөө, тушаал, заавар, журам) боловсруулах, үнэлэх, шинэчлэх • НЭМ-ийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн болон салбар хооронд (нэг эрүүл мэндийн үзэл баримтлал, хилийн нэвтрэх цэгүүд багтах)-ын мэдээлэл дамжуулах эрх зүйн орчныг бий болгох, холбогдох дүрэм журмыг боловсруулж, тогтвортой байдлыг хангах, үнэлэх, шинэчлэх			√	

1.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ


НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ

№	Үндсэн тусламж, үйлчилгээний багц	Дэд багц	Тусламж, үйлчилгээ	ЗОРИЛТОТ БҮЛЭГ				ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ				САЛБАР ДУНДЫН		Олон улсын болон иргэний нийгмийн байгууллага
				Сургууль	Ажлын байр	Хот/орон нутаг	Нийт хүн ам	Анхан шатлалын		ЭМГ/НЭМТ	НЭМАХҮТ	Хариуцах салбар	Дэмжих салбар	
								Өрхийн ЭМТ	Сум, тосгоны ЭМТ					
Нэг. Халдварт бус өвчин														
1.1	Дасгал, хөдөлгөөн 2,6,87,88	Эрсдэлт зан үйлийг бууруулах	Насны бүлэг (хүүхэд, өсвөр үе, насанд хүрэгчид, ахмадууд)-т тохирсон дасгал хөдөлгөөнийг зөвлөх88	√	√		√	√	√	√	√	ЭМЯ	БЯ, ГБХНХЯ, БТСУХ	√
			Зорилтот бүлэг (хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн болон амаржсан, архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй)-т тохирсон дасгал хөдөлгөөнийг зөвлөх88	√	√		√	√	√	√	√	ЭМЯ		
			Суугаа ажил, хөдөлмөр эрхэлдэг хүмүүст зориулсан зөвлөмжүүд88		√		√	√	√	√	√	ЭМЯ		

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ 5. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦОО БОЛОН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

№	Дэд багц	Тусламж, үйлчилгээ	НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА					ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА	
			АНХАН ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГА	ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГА	ЭМГ/НЭМТ	НЭМАХҮТ	ЭМЯ (ЭМДЕГ, ЭМХТ, ЭЭХХЗГ)	Бусад салбарын байгууллага	Олон улсын болон иргэний нийгмийн байгууллага
5.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, дагаж мөрдөх бодлогын болон бусад зохицуулалт84,85	Хууль тогтоомж санаачлах/шинэчлэх/нэмэлт/өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулах, төслөө боловсруулах • Судалгаа, нотолгоонд суурилсан мэдээлэл цуглуулах, шаардлагатай бол иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх; үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх; • Иргэн, хуулийн этгээд, олон нийтийн төлөөллийн оролцоотой хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах • Төрийн, төрийн бус, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, судалгааны байгууллагуудаас санал авах ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх УИХ-д өргөн мэдүүлэх83				√	√	ЗГ, УИХ, Холбогдох яамд, Судалгааны байгууллагууд	√

ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



- Төслийн удирдлага:
 - Эрүүл мэндийн яам
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:
 - ДЭМБ
 - НҮБ-ын Хүүхдийн Сан
- Нийт төсөв:
 - 15 сая ам.доллар
- Хэрэгжих хугацаа:
 - 2024-2026 он

Цартахлын сангийн эхний ээлжийн санхүүжилт хүлээн авсан улсууд

ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ЗОРИЛГО


Өвчний эрт сэрэмжлүүлэг, нэгдсэн тандалтын тогтолцоог чадавхжуулах, лабораторийн чанарыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээ авахад бэлэн байдлыг нэмэгдүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх замаар цартахлын эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахад оршино.



ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

Нэг эрүүл мэнд
зарчимд
тулгуурлан салбар
хоорондын хамтын
ажиллагааг
бэхжүүлэх



Нийгмийн эрүүл
мэндийн
тогтолцооны
чадавх, тогтвортой
байдлыг бэхжүүлэх



Цартахлын хариу
арга хэмжээнд
оролцох хүний
нөөцийг бэлтгэх



Нэн шаардлагатай
нийгмийн эрүүл
мэндийн болон
эрүүл мэндийн
тусламж
үйлчилгээг
тасралтгүй
үзүүлэхийн
зэрэгцээ хариу арга
хэмжээ авах
тогтолцооны хариу
үйлдэл үзүүлэх,
тэсвэртэй байдлыг
нэмэгдүүлэх

ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЗОРИЛТ

Зорилт 1: Тандалт, лабораторийн чадавхыг чадавхжуулж, эрт сэрэмжлүүлэх чадамжтай нэгдсэн тандалтын тогтолцоог бий болгох

- *Тандалт*
- *Лаборатори*

Зорилт 2: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулахын тулд хүний нөөцийн чадавхыг өргөжүүлж, бэхжүүлж, салбар дундын хамтын ажиллагаа, Нэг эрүүл мэндийн засаглал, удирдлагыг бий болгох

- *Хүний нөөц*
- *Салбар дундын хамтын ажиллагаа, Нэг эрүүл мэндийн засаглал*

ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- *Тандалт:*

- Эрт илрүүлэх үндэсний цахим тандалтын тогтолцоог бий болгох
- Үндэсний хэмжээнд зохицуулалтаар хангах үүрэг бүхий тандалт судалгааны төвийг байгуулах

- Лаборатори:*

- Тоног төхөөрөмж, хүний нөөцийн сургалт, олон улсад мөрдөгдөж буй норм, стандарт, журам, сайн туршлагыг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулах
- Зооноз, халдварт өвчин, бичил биетний тэсвэржилтийн чадавхыг бэхжүүлэх
- Генийн дараалал тогтоох чадавхыг өргөжүүлэх
- Биоаюулгүй байдал, биоаюулгүй ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох
- Чанарын гадаад хяналтын тогтолцоог бий болгох,

ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- *Хүний нөөц:*

- Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх салбар хоорондын хүний нөөцийг бэлтгэхэд Талбарын Тархвар Судлалын Сургалтын хөтөлбөрийг бэхжүүлэх

- Хүний нөөцийн цогц стратегийг боловсруулж хязгаарлагдмал байдлыг бууруулах

- Салбар дундын хамтын ажиллагаа, Нэг эрүүл мэндийн засаглал:*

- Нэг эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хууль эрх зүйн орчин, бүтэц, засаглалын механизм, зохицуулалт, санхүүжилтийг тодорхойлох үндэсний "Нэг эрүүл мэнд"-ийн асуудлыг зохицуулах зөвлөлийг байгуулах

- Нэг эрүүл мэндийн чиглэлийн үндэсний стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх



ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ МОНГОЛ УЛСЫН ЧАДАВХЫГ НЭГ ЭРҮҮЛ МЭНД ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН



ЦАРТАХЛЫН ДАРААХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2027)

Зорилго:

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлын хариу арга хэмжээнээс тогтвортой байдлын менежментэд шилжиж, болзошгүй цартахал, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний үндэсний чадавхыг бэхжүүлэхэд арга хэмжээний зорилго оршино.



2024 оны 04 сарын 18 өдөр
Дугаар А/180
Улаанбаатар хот

Цартахлын дараах эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Цартахлын дараах эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/-г нэгдүгээр, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ж.Байгалмаа/-д тус тус даалгасугай.
- Тушаалыг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Б.Амгаланбаяр/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /С.Өнөрсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Нийтийн эрүүл мэндийн газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэн, хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар /Л.Лувсан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт зөвлөсүгэй.



ЦАРТАХЛЫН ДАРААХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2027)

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахал бүртгэгдсэнээс хойшхи хугацаанд Монгол Улсын Засгийн газраас цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан халдварын тархалтыг бууруулах, хүндрэл багатай даван туулахад чиглэсэн бүхий л арга хэмжээг олон салбарын оролцоотойгоор хэрэгжүүлж ажилласан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахал нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн салбарын чадавхыг шалгасан том сорилт болсон төдийгүй эрүүл мэндийн салбарын хөгжлийн цаашдын чиг хандлагад өөрчлөлт оруулж, амьдралын шинэ хэв маягт дасан зохицох шаардлагыг бий болгож байна.

Иймд улс орнууд эрсдэлд суурилсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, тогтолцооны сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ДЭМБ-аас хүн амын эрсдэлд өртөмхий бүлгийг хамгаалах, эрүүл мэндийн салбарын ачааллыг зохицуулах, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн "Цартахлын хариу арга хэмжээнээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тогтвортой менежментэд шилжих" удирдамжийг боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээг тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй, тогтвортой авч хэрэгжүүлэхэд чиглэсэн 5 бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон. Үүнд:

- Олон талт хамтын тандал
- Олон нийтийн оролцоо, хамгаалал
- Аюулгүй, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ
- Хангамжийн бэлэн байдал
- Хариу арга хэмжээний нэгдсэн зохицуулалт

Манай Улсад КОВИД-19 цартахлын сургамжид тулгуурлан дээрх 5 чадавхыг бэхжүүлж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн салбарын тогтвортой байдлыг хангах шаардлага чухлаар тавигдаж байна.

Монгол Улсад халдварт өвчин, нянгийн тэсвэржилт, цаг агаарын эрс тэс үзэгдэл, газар хөдлөлт, үер, ган, гал түймэр, галт уулын дэлбэрэлт, технологийн аюул, сүүлийн үед эрчимжиж буй уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь олон сорилт авчирч, эрүүл мэндэд нөлөөлж байна.

Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах, ирээдүйн сорилтыг даван туулах арга замыг тодорхойлоход салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх,

ЦАРТАХЛЫН ДАРААХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2027)

Зорилт:

- Болзошгүй цартахал, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын чадавхыг бэхжүүлж, төлөвлөлт, зохион байгуулалт, санхүүжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг шуурхай мэдээлэх тандалтыг бодит цагийн горимд шилжүүлэх, лабораторийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, хувилбарын тандалтыг өргөжүүлж, бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлэх;
- Хүн амд чанартай тусламж үйлчилгээг жигд, хүртээмжтэй хүргэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах;
- Цартахал, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амд зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах, эрсдэлийн харилцаа холбоог олон нийтийн оролцоонд тулгуурлан өргөжүүлэх;
- Хилийн нэвтрэх цэгийн эрх зүйн орчныг сайжруулж, хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх.

ТТӨ-ИЙ БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

• ЭМС-ын 2022 оны А/373 дугаар тушаал



ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ТАРХАЛТЫН ҮЕ ШАТЫГ ТОГТООХ ЗААВАР

- 1.1. Улс, нийслэл, аймгийн ТТӨ-ий тархалтын үе шатыг ДЭМБ-аас гаргасан “Улирлын томуу, томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХҮ)-ний аргачлалаар тодорхойлно.
- 1.2. ТТӨ-ий тархалтын үе шатыг “Улирал хоорондын үе”, “Идэвхжлийн үе”, “Алаг цоог дэгдэлтийн үе”, “Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт”, “Тахалт тархалт” гэж 5 ангилна.
- 1.3. ТТӨ-ий тархалтын үе шатыг халдварлалт, хүндрэлийн зэрэг, үр нөлөө гэсэн 3 зэрэгт хуваагдах шалгуур үзүүлэлтээр тогтооно.
- 1.4. Шалгуур үзүүлэлт тус бүрийг тодорхойлоходоо өөрт тохирох хэмжүүрийг сонгоно (Хүснэгт 1).


Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийг тодорхойлоход хэрэглэгдэх хэмжүүр

Шалгуур үзүүлэлт	Хэмжүүр
Халдварлалтын зэрэг	- 10,000 хүн ам дахь ТТӨ - Томуугийн вирус эерэг гарсан хувь - 10,000 хүн ам дахь ТТӨ-ий тохиолдол буюу томуу эерэг гарсан хувийн нийлмэл утга
Хүндрэлийн зэрэг	- АЗЦХХ-ын нас баралт/АЗЦХХ-ын тохиолдол - 10,000 хүн ам дахь АЗЦХХ/10,000 хүн ам дахь ТТӨ - АЗЦХХ-ын доторх томуу эерэг гарсан хувь, ТТӨ доторх томуу эерэг гарсан хувь - АЗЦХХ-ын нийлмэл утга / ТТӨ-ий нийлмэл утга
Үр нөлөө	- 10,000 хүн ам дахь АЗЦХХ-ын тохиолдол - 10,000 хүн ам дахь ТТӨ болон томуу эерэг гарсан хувийн нийлмэл утга - АЗЦХХ-ын шалтгаант орны ачаалал - Эмийн сангийн борлуулалтын мэдээ

- 1.5. Тархвар судлалын 7 хоног бүрийн өвчлөлийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт тус бүрээр гарган босго үзүүлэлттэй харьцуулж матрицаар үнэлэн ТТӨ-ий тархалтын үе шатыг тогтооно.
- 1.6. ТТӨ-ий тархалтын үе шатыг дараах шалгуурыг ашиглан тогтооно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Үе шат тодорхойлох шалгуур

Үе шат	Шалгуур
Улирал хоорондын үе	ТТӨ-ий идэвхжилгүй үеийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 2 долоо хоног дараалан доогуур байгаа тохиолдолд
Идэвхжлийн үе	“Улирал хоорондын” үеийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 2 долоо хоног дараалан давсан тохиолдолд
Алаг цоог дэгдэлтийн үе	“Идэвхжлийн үе”-ийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 2 долоо хоног дараалан давсан тохиолдолд
Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт	“Алаг цоог дэгдэлтийн үе”-ийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 1 долоо хоног давсан тохиолдолд
Тахалт тархалт	“Улсын хэмжээний дэгдэлтийн үе”-ийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 1 долоо хоног давсан тохиолдолд



• Улсын хэмжээнд ТТӨ-ий тархалтын түвшин “Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХҮ)”-гээр **ИДЭВХЖЛИЙН ТҮВШИНД** байна.

• Улирал хоорондын түвшинд 2 (өмнөх долоо хоногт 3), идэвхжлийн түвшинд 16 (өмнөх долоо хоногт 15) аймаг, Улаанбаатар хот байна.

2024 оны 41 дүгээр долоо хоног



Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалтыг өргөжүүлэх журмыг нэгдүгээр, Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх зааврыг хоёрдугаар, Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинг тогтоох зааврыг гуравдугаар, Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээний чиглэлийг дөрөвдүгээр, лабораторид суурилсан тандалтын зааврыг тавдугаар, Томуугийн харуулдан тандалтын нэгж, вирус судлалын лабораторийн жагсаалтыг зургаадугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх зааврыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын мэдээ, мэдээлэл солилцоо, бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар /Д.Нарантуяа/, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга нарт даалгасугай.

3. Вирус судлалын лавлагаа, бүсийн болон салбар лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, оношлуурын зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт даалгасугай.

4. Интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн системийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, лабораторийн шинжилгээ, хариу арга хэмжээний мэдээлэл цуглуулахад ашиглаж буй цахим програмтай үе шаттай нэгтгэх ажлыг зохион байгуулж, цахимын аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д үүрэг болгосугай.

ТТӨ-ИЙ БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

ТТӨ-НИЙ ДЭГДЭЛИЙН ҮЕД ТУТ ИДЭВХЖИХ ҮЕ ШАТНЫ ЗУРАГЛАЛ



- **ТТӨ-ний дэгдэлтийн үед ТУТ-ны зарчмаар ажиллах**
- Үндэсний түвшинд ЭМЯ/ХӨСҮТ
- Аймаг, дүүргийн түвшинд ЭМГ



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

